

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/133/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/43
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга нь Өмгөөллийн Ренчин ХХН-тэй хуулийн зөвлөх үйлчилгээ авах гэрээг байгуулж үйлчилгээний төлбөр болох 40,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, хуульд заагаагүй нэмэгдлийг улс төрийн албан хаагчдад эхний 6 сар олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын ХУР системээр иргэдэд цахим үнэмлэхээр 18 байгууллагын 160 үйлчилгээг 254 иргэнд үзүүлсэн байна. Мөн Emongolia аппликейшнийг 216 иргэний гар утсанд суулгасан ба ашиглах зөвлөгөө зааврыг цахимаар 4,9 мянган иргэнд сурталчлан таниулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар зам гүүрний байгууламж болон сумын тохижилтын талбай, гэрэл, чийрэгжүүлэлтийн төхөөрөмжийг 184,313.2 мянган төгрөгөөр хийж бүтээн байгуулалтаа нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүссэн тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,409,389.7	105,393,536.6
33	АВЛАГА	760,723.4	14,100,368.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	44,355.4	0.0
335	Бусад авлага	716,368.0	14,100,368.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	716,368.0	14,100,368.0
35	БАРАА МАТЕРИАЛ	91,648,666.4	91,293,168.6
354	Хангамжийн материал	86,648,666.4	86,293,168.6
35410	Бичиг хэргийн материал	961,150.0	1,229,825.0
35420	Аж ахуйн материал	49,443,820.0	47,672,320.0
35450	Барилгын засварын материал	0.0	770,000.0
35470	Бусад хангамжийн материал	36,243,696.4	36,621,023.6
35600	Мал амьтад	5,000,000.0	5,000,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,542,751,768.6	2,364,101,699.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,542,751,768.6	2,364,101,699.4
392	Биет хөрөнгө	1,409,469,102.0	2,231,090,699.6
39201	Барилга, байгууламж, орон сууц	807,880,657.0	807,880,657.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-452,841,228.2	-393,091,136.1
39203	Авто-тээврийн хэрэгсэл	282,079,757.2	547,969,440.2
39204	Хуримтлагдсан элэгдэл	-172,265,667.7	-164,086,349.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	329,193,238.0	346,698,288.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-207,710,162.8	-224,029,307.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,824,781.0	36,859,234.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,638,233.3	-23,876,629.5
39209	Зам, гүүрийн байгууламж	439,123,410.0	549,703,894.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-320,713,588.5	-363,571,423.2
39214	Бусад үндсэн хөрөнгө	959,337,459.0	1,496,221,045.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-262,801,319.7	-385,587,013.7
393	Биет бус хөрөнгө	133,282,666.6	133,010,999.8
39301	Програм хангамж	2,040,000.0	2,040,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,643,333.4	-1,915,000.2
39303	Бусад биет бус хөрөнгө	132,886,000.0	132,886,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,635,161,158.3	2,469,495,236.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	203,368.0	116,368.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	203,368.0	116,368.0
413	Өглөг	203,368.0	116,368.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,000.0	0.0
4136	Бусад өглөг	199,368.0	116,368.0
41361	Байгууллагад төлөх өглөг	183,368.0	100,368.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	16,000.0	16,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,634,957,790.3	2,469,378,868.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,634,957,790.3	2,469,378,868.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	916,474,832.4	916,474,832.4
51101	Өмч: - төрийн	916,474,832.4	916,474,832.4
512	Хуримтлагдсан үр дүн	528,256,485.8	1,399,285,809.6
51210	Өмнөх үеийн үр дүн	528,256,485.8	564,440,731.8
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	834,845,077.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	190,226,472.1	153,618,226.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,635,161,158.3	2,469,495,236.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,074,973,768.8	2,067,949,661.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	354,166,151.0	1,039,382,331.0
120	Нийтлэг татварын бус орлого	354,166,151.0	1,039,382,331.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	346,591,151.0	1,032,312,331.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	7,575,000.0	7,070,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	720,807,617.8	1,028,567,330.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,499,717.8	82,976,930.4

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,508,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,216,090.0	66,786,025.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,775,627.8	16,190,905.4
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	649,307,900.0	945,590,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	649,307,900.0	945,590,400.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	928,753,447.9	1,232,154,608.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	850,000,224.9	1,086,828,494.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	779,745,768.0	1,044,231,212.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,594,497.6	429,762,642.2
210101	Үндсэн цалин	169,502,243.3	241,531,947.5
210102	Нэмэгдэл	31,092,254.4	141,413,887.8
210104	Урамшуулал	0.0	46,816,806.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,594,278.9	54,259,004.9
210201	Тэтгэврийн даатгал	17,436,386.9	36,895,982.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,339.6	4,340,855.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,630,991.8	3,702,850.0
210204	Ажилгүйдлийн даатгал	398,081.3	868,111.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,077,479.4	8,451,205.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,061,816.1	57,386,229.4
210301	Гэрэл, цахилгаан	10,554,504.1	14,620,725.4
210302	Түлш, халаалт	32,817,312.0	41,325,504.0
210303	Цэвэр, бохир ус	690,000.0	1,440,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	96,497,425.7	60,194,100.0
210401	Бичиг хэрэг	6,492,050.0	5,695,125.0
210402	Тээвэр, шатахуун	31,384,100.0	27,328,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,612,000.0	7,927,775.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,972,900.0	12,700,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,985,780.0	4,366,500.0
210408	Бараа материал акталсны зардал	39,050,595.7	2,176,200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,381,500.0	12,101,700.0
210604	Урсгал засвар	38,381,500.0	12,101,700.0
2107	Томилолт, зочны зардал	7,249,600.0	5,294,400.0
210702	Дотоод албан томилолт	7,249,600.0	5,294,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,268,538.4	46,370,721.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,664,070.4	43,432,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	640,000.0	820,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	246,950.0	307,395.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,011.0	1,178,926.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	117,000.0
210807	Газрын төлбөр	404,507.0	515,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	317,098,111.4	378,862,415.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,904,817.0	44,073,355.7
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	216,193,294.4	334,789,059.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,254,456.9	42,597,281.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,914,271.1	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,914,271.1	2,500,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,340,185.8	40,097,281.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,340,185.8	40,097,281.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,753,223.0	145,326,114.4
2200	Дотоод эх үүсвэрээр	78,753,223.0	145,326,114.4
221001	Их засвар	71,853,223.0	60,124,600.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	35,874,395.0
223001	Бусад хөрөнгө	6,900,000.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,220,320.9	835,795,052.8
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	350.0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.0	350.0
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	950,325.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.0	950,325.0

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.0	-949,975.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	146,220,320.9	834,845,077.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	720,807,617.8	1,028,567,330.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	720,807,617.8	1,028,567,330.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,499,717.8	82,976,930.4
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,508,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,216,090.0	66,786,025.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,775,627.8	16,190,905.4
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	649,307,900.0	945,590,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	649,307,900.0	945,590,400.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	612,894,694.8	760,694,231.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	612,894,694.8	760,694,231.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,640,238.0	718,096,950.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,594,497.6	429,722,286.8
210101	Үндсэн цалин	169,502,243.3	241,491,592.1
210102	Нэмэгдэл	31,092,254.4	141,413,887.8
210104	Урамшуулал	0.0	46,816,806.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,594,278.9	54,259,004.9
210201	Тэтгэврийн даатгал	17,436,386.9	36,895,982.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,339.6	4,340,855.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,630,991.8	3,933,155.6
210204	Ажилгүйдлийн даатгал	398,081.3	868,111.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,077,479.4	8,220,899.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,061,816.1	57,386,229.4
210301	Гэрэл, цахилгаан	10,554,504.1	14,620,725.4
210302	Түлш, халаалт	32,817,312.0	41,325,504.0
210303	Цэвэр, бохир ус	690,000.0	1,440,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	61,188,980.0	60,287,775.0
210401	Бичиг хэрэг	7,412,300.0	5,250,000.0
210402	Тээвэр, шатахуун	31,384,100.0	27,328,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,612,000.0	7,927,775.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,500,000.0	15,500,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,280,580.0	4,281,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,281,500.0	12,101,700.0
210604	Урсгал засвар	39,281,500.0	12,101,700.0
2107	Томиллолт, зочны зардал	7,249,600.0	5,294,400.0
210702	Дотоод албан томиллолт	7,249,600.0	5,294,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,268,538.4	46,370,721.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,664,070.4	43,432,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	640,000.0	820,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	246,950.0	307,395.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,011.0	1,178,926.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.0	117,000.0
210807	Газрын төлбөр	404,507.0	515,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,401,027.0	52,674,833.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,401,027.0	52,674,833.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,254,456.9	42,597,281.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,914,271.1	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,914,271.1	2,500,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,340,185.8	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,340,185.8	0.0

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	40,097,281.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	40,097,281.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	107,912,923.0	267,873,099.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	107,912,923.0	267,873,099.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,912,923.0	267,873,099.0
2200	Дотоод эх үүсвэрээр	107,912,923.0	267,873,099.0
221001	Их засвар	7,250,000.0	47,644,600.0
222001	Тоног төхөөрөмж	0.0	2,102,900.0
223001	Бусад хөрөнгө	9,105,900.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	91,557,023.0	218,125,599.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-107,912,923.0	-267,873,099.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.4	190,239,732.1	382,135,404.9	1,488,849,969.4
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(99,240.0)	(99,240.0)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.4	190,239,732.1	382,036,164.9	1,488,750,729.4
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	146,220,320.9	146,220,320.9
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.4	190,226,472.1	528,256,485.8	1,634,957,790.3
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.4	190,226,472.1	528,256,485.8	1,634,957,790.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	36,184,246.0	36,184,246.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	916,474,832.4	190,226,472.1	564,440,731.8	1,671,142,036.3
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(36,608,246.0)	-	(36,608,246.0)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	834,845,077.8	834,845,077.8
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	916,474,832.4	153,618,226.1	1,399,285,809.6	2,469,378,868.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	945,547,400.0	908,934,990.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,030,700.0	664,071,891.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	691,530,700.0	661,571,891.8

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,572,300.0	390,216,735.4
210101	Үндсэн цалин	220,513,800.0	232,804,797.3
210102	Нэмэгдэл	113,247,500.0	110,595,131.2
210104	Урамшуулал	60,811,000.0	46,816,806.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,321,400.0	49,320,811.0
210201	Тэтгэврийн даатгал	33,538,600.0	33,538,011.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,945,800.0	3,945,800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,156,500.0	3,386,805.6
210204	Ажилгүйдлийн даатгал	789,100.0	789,100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,891,400.0	7,661,094.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,818,200.0	57,386,229.4
210301	Гэрэл, цахилгаан	16,804,800.0	14,620,725.4
210302	Түлш, халаалт	52,573,400.0	41,325,504.0
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.0	1,440,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	60,267,000.0	60,194,775.0
210401	Бичиг хэрэг	5,250,000.0	5,250,000.0
210402	Тээвэр, шатахуун	27,235,500.0	27,235,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,000,000.0	7,927,775.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,500,000.0	15,500,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,281,500.0	4,281,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,101,700.0	12,101,700.0
210604	Урсгал засвар	12,101,700.0	12,101,700.0
2107	Томилолт, зочны зардал	5,294,400.0	5,294,400.0
210702	Дотоод албан томилолт	5,294,400.0	5,294,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,468,500.0	46,370,721.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,500,000.0	43,432,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	820,000.0	820,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	311,100.0	307,395.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,200,000.0	1,178,926.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.0	117,000.0
210807	Газрын төлбөр	472,400.0	515,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,687,200.0	40,686,520.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,687,200.0	40,686,520.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.0	2,500,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.0	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.0	2,500,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	251,516,700.0	244,863,099.0
2200	Дотоод эх үүсвэрээр	251,516,700.0	244,863,099.0
221001	Их засвар	194,926,700.0	193,875,699.0
222001	Тоног төхөөрөмж	56,590,000.0	50,987,400.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	945,547,400.0	908,934,990.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	945,547,400.0	908,934,990.8
132001	Орон нутгийн төсвөөс	945,547,400.0	908,934,990.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.0	58,301.0
620001	Удирдах ажилтан	555.0	7,878.0
620002	Гүйцэтгэх ажилтан	455.0	4,545.0
620003	Үйлчлэх ажилтан	10.0	45,878.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,389,977.00	79,535,058.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,389,977.00	79,535,058.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,270,777.00	79,535,058.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	39,505,551.44
210101	Үндсэн цалин	-	8,686,794.78
210102	Нэмэгдэл	-	30,818,756.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,938,193.92
210201	Тэтгэврийн даатгал	-	3,357,971.88
210202	Тэтгэмжийн даатгал	-	395,055.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	546,350.01
210204	Ажилгүйдлийн даатгал	-	79,011.10
210205	Эрүүл мэндийн даатгал	-	559,805.42
2104	Хангамж, бараа материалын зардал	2,388,800.00	93,000.00

210402	Тээвэр, шатахуун	2,388,800.00	93,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,881,977.00	34,998,313.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,881,977.00	34,998,313.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,119,200.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,119,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,119,200.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,499,717.80	79,535,058.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,499,717.80	79,535,058.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,508,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,216,090.00	66,620,408.36
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,775,627.80	12,914,650.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 19 зорилт, хэрэгжүүлэх 81 арга хэмжээтэй баталснаас нийт 94.4 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. 2023 онд тус байгууллагад Сумын засаг даргын А/25 захирамжийн дагуу Дотоод хяналтын баг шилэн дансны мэдээлэлд, тээвэр шатахуунд, нөөцийн өвс тэжээлд, өр авлага барагдуулалт, худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт тус тус дотоод хяналт хийгдсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 358.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт өгөгдсөн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2023.03.03-ны өдрийн А/07 тушаалаар баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 834,334.1 мянган төгрөгөөр буюу 51 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	760.7	14,100.4	13,339.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	91,648.7	91,293.2	(355.5)
Үндсэн хөрөнгө	1,542,751.8	2,364,101.7	821,349.9
Нийт хөрөнгө	1,635,161.2	2,469,495.2	834,334.1
Өр төлбөр	203.4	116.4	(87.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,634,957.8	2,469,378.9	834,421.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,635,161.2	2,469,495.2	834,334.1

Дээрх хүснэгтээс харахад: Авлага дансны үлдэгдэл 13,339.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шилжих үлдэгдлээс Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийн засварын ажлыг иргэн Доржбат гүйцэтгэхээр 14,000.0 гэрээ байгуулсан боловч ажлаа дуусгаж амжаагүйтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 355.5 мянган төгрөг болж буурсан нь 1582 нэр төрлийн 7.1 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй дансанд бүртгэгдсэн. 140.7 сая төгрөгийн материал бэлтгэж, 162 нэр төрлийн 2.2 сая төгрөгийн материал акталсан. 1217 нэр төрлийн 22.1 сая төгрөгийн бараа материалыг балансаас баланс руу шилжүүлсэн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 821,349.9 мянган төгрөг болж өссөн нь 79 нэр төрлийн 116.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, 973 нэр төрлийн 1,011.3 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогдож авч 64 нэр төрлийн 89,348.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 79 нэр төрлийн 124.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, 228 нэр төрлийн 97.8 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланс руу шилжүүлсэн ба 239.5 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,469,379.0 мянган төгрөг болж 834,421.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засаг даргын тамгын газар нь 2023 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 606,463.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 46,976.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 653,439.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд батлагдсан төсөвт өөрчлөлт орж 945,590.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Энэ нь 2023 онд алба хаагчдын цалин шат дараатайгаар нэмэгдсэнээс шалтгаалан орон нутгийн төсвийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 653,439.4 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 945,590.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Урьд оны үлдэгдлээс санхүүжсэн дүн 198,742.5 мянган төгрөг, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 909.0 сая төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 36.6 сая, төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	19,325.0	19,325.0	0	100%
2	70106/ 80106 Баг хорооны ҮА зардал	579,420	552,510.7	26,909.1	95%
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	77,828.7	74,735.9	3,092.7	96%
4	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,500.0	2,500.0	0	100%
5	70106/80918 Бусад	251,516.7	244,863	6,653.6	97.3%
6	70106/ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	15,000.0	0	100%
7	70106/82801 Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%
8	71411/81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	3,825.0	3,825.0	0	100%
9	71411/82212 Хур хог хаягдал, орчныг бохирдол	15,500.0	15,500.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд өвс тэжээлийн нөөц 15,927.7 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 862.6 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 25.0 мянган төгрөг, ажлын байрны түрээс 210.8 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 6,169.2 мянган төгрөг, дуудлага худалдаа дэнчин 20,640.0 мянган төгрөг, Сүүн баярын 1-р байр шагнал 1,000.0 мянган төгрөг, Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 44,609.3 мянган төгрөг, Цахим тендер бичиг баримтын үнэ 814.3 мянган төгрөг, Жаргал худаг эрсдэлийн сангаас 32.0 мянган төгрөг, нэр данс зөрүү орлого Байгальмаа 50,0 мянган төгрөг, Төв-100 гэрлэн чимэглэл 19,600.0 мянган төгрөг, нийт 109,940.9 мянган төгрөгийн орлого орсон байна.

Төрийн захиргааны албан хаагчийн орон нутгийн нэмэгдэл цалин 44,443.7 мянган төгрөг, ажлын байрны түрээсэнд 210.8 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж дансанд 25.0 мянган төгрөг, нэр данс зөрүү орлогыг Тө.БЧ татварын бус орлогод 50.0 мянган төгрөг, Сүүн баярын арга хэмжээг бэлтгэж зохион байгуулсан албан хаагчдад урамшуулал 1,000.0 мянган төгрөг, Хагас жилийн мат тооллогын урамшуулалд 350.2 мянган төгрөг, шатахууны зардалд 512.0 мянган төгрөг, 2023 оны санхүүгийн аудитын төлбөрт 6,169.2 мянган төгрөг, дуудлага худалдаа дэнчин буцаалт 20,400.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,054.3 мянган төгрөг, Өндөр гурван тогтох ХХК Төв-100 гэрлэн чимэглэл 19,600.0 мянган төгрөг, сумын өвс нөөц бэлтгэх шатахууны зардалд ОБЕГ тэжээлийн үнэ 1,033.6 мянган төгрөг, Дэвжих мандал ХХК хивэг 4,797.0 мянган төгрөг, Милл хаус ХХК хивэгний зардалд 3,750.0 мянган төгрөг, шатахууны зардалд 3,103.3 мянган төгрөгийн зардлыг шилжүүлж 3,441.8 мянган төгрөг татан төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106/ орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	95.5%	926,265.4	884,610.0
2	71411/Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	хэвийн үйл ажиллагааг хангах	100%	19,325.0	19,325.0

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 397,662.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд тээвэр шатахууны зардлыг НИК ХХК, түлш халаалтын зардлыг Винтер гарден ХХК, гэрэл цахилгааны зардлыг УБЦТС ХК шууд гэрээ байгуулан нийт 82,231.2 төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Сумын ариутгах татуургын төв шугамын угсралт ажлыг гүйцэтгэхээр Мөнхзүмбэр ХХК нээлттэй тендер шалгаруулалтаар шалгаран 99,099.9 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийг Саммит компьютер технологи ХХК-аас ерөнхий гэрээгээр 10,351.2 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

Өмгөөллийн Ренчин ХХН-тэй 40,000.0 мянган төгрөгийн хуулийн зөвлөх үйлчилгээ авах гэрээг шууд байгуулж үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн зөрчил гаргасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 744,756.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,171.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,378.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 169 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 167 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21 орлогын, 12 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлсэн ба төсөв зарцуулах 11 шийдвэр, тендэрт шалгарсан оролцогчийн талаарх товч мэдээлэл цэсэд 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудитаар 4 зөвлөмж, 1 төлбөрийн акт тавигдсан. Зөрчлийг бүрэн арилгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 3 албан шаардлага өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 05/159 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	3	32.350.7	3	32.350.7	100%
Зөвлөмж	2	12,702.0	2	12,702.0	100%
Нийт дүн	5	45.052.7	5	45.052.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар илэрсэн алдаа байхгүй.

5.1 Төлбөрийн акт

1. Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.

Илрүүлэлт: Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/03 захирамжийг үндэслэн сумын Улс төрийн 5 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 8,960.8 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх,

төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

2. Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал цалин олгосон.

Илрүүлэлт: Баянчандмань сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/55 захирамж, Баянчандмань сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/48 тушаалыг үндэслэн сумын улс төрийн 2, үйлчилгээний 3 албан хаагчид урамшуулал цалин 2,163.5 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмгөөллийн Ренчин ХХН-тэй 40,000.0 мянган төгрөгийн хуулийн зөвлөх үйлчилгээ авах гэрээг байгуулж үйлчилгээний төлбөрийг шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.2-т "Төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 "Сахилга баттай байх", 4 дүгээр зүйлийн 4.1.9 "Хариуцлагатай байх" болон санхүүгийн тайлангийн аудитын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Баянчандмань сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 5 газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн газрын бүртгэлд 12 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана", 23 дугаар зүйлийн 23.3.9 "Аймаг нийслэлийн газрын алба нь газар эзэмших,

ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх эрхтэй”, 23 дугаар зүйлийн 23.4.3 “Сумын газрын даамал, дүүргийн газрын алба нь эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх эрхтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай тооцоо нийлэх, зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл цалин олгосон.	1	8,960.8	1	8,960.8	-	-	-	-	-	-	-	-
Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал цалин олгосон	1	2,163.5	1	2,163.5	-	-	-	-	-	-	-	-
Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	1	40,000.0			1	40,000.0						
Дүн	3	51,124.3	2	11,124.3	1	40,000.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газрын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянжчандмань сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгийн бүртгэлд 5 газар, ГХБХБГ-аас ирүүлсэн газрын бүртгэлд 12 газар бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэгдсэн газрын тоо болон үнэлгээний дүн тус тус зөрүүтэй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn